

**“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн  
С.Цэнд-Аюушийн 2023 оны сүүлийн хагас жилд хийсэн ажлын товч тайлан**

“Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн миний бие Монгол Банкны Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А-86 тоот тушаалаар батлагдсан “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүргийг биелүүлж ажиллаа. Тухайлбал:

**Журмын 5.2.1-д заасны дагуу:**

**НЭГ. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал.**

Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны сүүлийн хагас жилд 5 удаа хуралдаж 17 асуудал хэлэлцсэн бөгөөд миний бие хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотой асуулт асууж, хариулт авч шийдвэрийн төсөлд санал дүгнэлтээ бүрэн тусгуулж ажилсан.

**ХОЁР. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал.**

2023 оны сүүлийн хагас жилд ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороог 7 удаа удирдан хуралдуулж нийт 18 асуудал хэлэлцэж асуудал тус бүр дээр шийдвэр гаргаж ажилласан.

Тухайлбал, Аудитын хорооны хурлаар Банкны худалдан авалтын 2, 3-р улирлын үйл ажиллагаанд ДАГ-ын хийсэн аудитын тайлан, ДАГ-ын 2023 оны 2, 3-р улирлын аудитын ажлын тайлан, Банкны 2023 оны 2,3 дугаар улирлын үйл ажиллагааны тайлан, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны 2,3 дугаар улирлын тайлан, Активыг эрсдэлийн сангаас хорогдуулах тухай, Төрийн банк ХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай, Төрийн банкны 2024-2026 оны стратеги төлөвлөгөөний төсөл, 2024 оны Бизнес төлөвлөгөөний төсөл, Төрийн банкны 2024 оны Санхүү, Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл, Дотоод аудитын газрын 2024 оны үйл ажиллагааны төсвийн төсөл зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрүүдийг гаргасан. 2024 оны Бизнес төлөвлөгөөний төсөлд тусгагдсан үйл ажиллагааны стратеги зорилт, төслүүдийг хэрэгжүүлсэнээр банк хариуцлагатай эрсдэлгүй үйл ажиллагааг эрхэмлэн харилцагчидын итгэлийг хүлээсэн нэр хүндтэй банк байж ажлаа ахисан түвшинд хүргэх зорилтыг тодорхой тусгах үүрэг өгсөн.

Аудитын хорооны хурлаар хэлэлцэж байгаа асуудлуудтай холбоотой үүрэг даалгаварыг өгч биелэлтэд нь хяналт тавьж ажилдаг. Тухайлбал, нийт зээлд эзлэх чанаргүй зээл, ангилагдсан зээл тогтоосон хэмжээнээс хэтэрч байгаад онцгой анхаарч чанаргүй зээлийг төлүүлэх, активын чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, зээл олголтод тавих хяналтыг бүх түвшинд сайжруулах, зээлийн эрсдэлийг бууруулах, чанаргүй зээл бий болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2024 оноос эхлэн Төрийн банкны төвийн зээлийн хороодын ажлыг хагас жил дутамд, банкны салбар болон тооцооны төвийн зээлийн хороодын ажлыг улирал дутам шалгаж, хяналт тавьж, биелэлтийг ТУЗ-д танилцуулж ажиллах үүрэг даалгавар өгсөн.

Төрийн банк ХК-ийн Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу банкинд үр ашигтай сонгон шалгаруулалт хийх, гэрээний биелэлтэд удирдлагын зүгээс тавих хяналтыг сайжруулах үүрэг болгосон шийдвэр гаргасан.

Төрийн банкны 2023 оны 2,3 дугаар улирлын үйл ажиллагааны тайлангаар бизнес төлөвлөгөөний биелэлт хангалтгүй, ажил хариуцсан газар, хэлтэс, албад хариуцсан ажил үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгааг Аудитын хороо дүгнэж, Дотоод аудитын газрын зөвлөмж, үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, аудитын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалыг арилгаж ажиллах үүрэг өгсөн.

Активыг эрсдэлийн сангаас хорогдуулах тухайд төлөгдөх найдваргүй гэж үзэж байгаа кредит картны болон тэтгэврийн зээлийн өрийг төрийн өмчийн банкны алдагдал болгож хаахыг дэмжээгүй бөгөөд кредит картны болон тэтгэврийн зээлийн төлөлтөд эрсдэл учирч байгаа шалтгааныг арилгахын тулд одоогийн мөрдөгдөж байгаа журмыг яаралтай шинэчлэн боловсронгуй болгох асуудлыг ТУЗ-өөр хэрэлцүүлж шийдвэрлүүлэх үүрэг өгсөн.

Мөн банкны хөрөнгө оруулалтын ажлын явц хангалтгүй байгаа тул ажил сайжруулах талаар зөвлөмж, чиглэл өгч одоогийн ашиглаж байгаа хүснэгтүүдийг өөрчлөн сайжруулж өгсөн бөгөөд 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан барилга, их засварын ажлыг энэ онд багтаан дуусгаж ашиглалтад оруулах, газар, хэлтэс, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах, цаг хугацаа алдаж тендер зарлаж байгаад дүгнэлт хийж, оны эхэнд бүх тендерийг зарладаг болох, батлагдсан ажлыг хугацаанд нь дуусгаагүй тухайн ондоо хөрөнгөө ашиглаж чадаагүй ажлыг дараа онд шилжүүлэхгүй байх, үүнээс үүдэн гарах хохирлыг буруутай этгээдээр хариуцуулдаг болох, үүнтэй холбогдуулан хөрөнгө оруулалтын одоогийн мөрдөгдөж байгаа журмыг шинэчлэх зэрэг үүрэг даалгавар өгсөн болно.

Хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөөний төслийг боловсруулах хүснэгт, үзүүлэлтүүдийг шинээр гарган хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг дахин хороогоор хэлэлцүүлсэн бөгөөд банкыг нэр хүндийн эрсдэлээс хамгаалах зорилгоор банкны гадна, дотор өнгө үзэмжийг сайжруулах, банкны ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх, харилцагчдын тав тухтай үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх, банкны мэдээлэлийн болон хамгаалалтын системийн аюулгүй, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд анхаарч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг хянаж, ТУЗ-ийн хуралд оруулан шийдвэрлүүлээ.

### **Гурав. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал**

2023 оны сүүлийн хагас жилд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо 5 удаа хуралдаж 10 асуудал хэлэлцсэн бөгөөд хорооны гишүүний хувиар хуралдаа идэвх санаачлагатай оролцож, асуулт асууж, хариулт аван хурлаас гарах шийдвэрт өөрийн саналаа тусгаж ажилсан.

Зээл олгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журам, зааврыг баримтлан олгож байхыг хатуу анхаарах, зээлийн эрсдэлийн дүгнэлтийг чанд сахин, зээлийн эрсдэл болон хуулийн дүгнэлтээр тавьсан нэмэлт шаардлагуудыг хангуулсны дараа зээлийг олгож байхад хатуу анхаарч, хяналт тавих, зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх, барьцаанд авахдаа хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлэн үнэлэх, томоохон зээлдэгчидтэй холбоотой шүүх болон шүүхийн бус үйл ажиллагааг идэвхжүүлэх, зээлийг төлүүлэх ажилгааг идэвхжүүлэх зэрэг санал гаргаж шийдвэрт тусгуулсан.

**3. Журмын 5.2.2-д заасны дагуу:** ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн асуудалд зарчмын эсрэг байр суурьтай асуудал байгаагүй болно.

**Журмын 5.2.3-д заасны дагуу:** 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал болон ТУЗ-ийн хурлаар Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл авах тухай асуудлыг хэлэлцсэн.

Хөгжлийн банкнаас өөрийн эзэмшиж байгаа Эрдэнэс тавантолгой ХК-ийн гаргасан 40 тэрбум төгрөгийн жилийн 10 хувийн өгөөжтэй бондыг Төрийн банкинд хямдралтай үнээр худалдах саналыг Аудитын хороогоор хэлэлцүүлж банкны ашигт ажиллагаа, зохистой харьцааны үзүүлэлтүүдэд эерэг нөлөөлөл гарах тооцооллыг үндэслэн худалдан авах гэрээг жилийн 17 хувийн өгөөжтэй байхаар хэлцэл хийхийг, хорооноос дэмжсэн шийдвэр гаргасан бөгөөд ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж хэлцэл хийх зөвшөөрлийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсөн шийдвэр гарсан.

**Журмын 5.2.4-д заасаны хүрээнд** Компанийн тухай хуулийн 79.3.1 дэх заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдын хурлыг хуралдуулах шаардлага үүсээгүй болно.

Компанийн тухай хуулийн 79.3.2 дахь заалтын дагуу Хараат бус гишүүний ажлын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Мөн хуулийн 79.3.2 дахь заалтын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож байгаа бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.


**Журмын 5.2.5-д заасаны дагуу:**

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4.1 дэх заалтад Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд *"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авалтын талаар санал боловсруулах"*, 79.4.2 дахь заалтад *"гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих"* гэж заасны дагуу Банкны худалдан авах ажиллагаа болон хөрөнгө оруулалтын ажлын явцыг Дотоод аудитын газар улирал бүр шалгаж ТУЗ, Аудитын хороонд танилцуулж байх талаар санал гаргаж, Дотоод аудитын газрын 2023 оны ажлын төлөвлөгөөнд нь тусгуулсан бөгөөд ДАГ улирал бүр худалдан авах ажиллагаа болон хөрөнгө оруулалтын ажлын явцыг шалгаж дүнг Аудитын хороо болон ТУЗ-д танилцуулж байна.

Энэ ажлын хүрээнд ДАГ-аас Худалдан авалтын 2, 3 дугаар улирлын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг Аудитын хорооны хурлаар хэлэлцэж, Төрийн банк ХК-ийн Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг чанд баримтлан, банкинд үр ашигтай сонгон шалгаруулалт хийх, гэрээний биелэлтэд удирдлагын зүгээс тавих хяналт сул байснаас олон төрлийн зөрчил гарч худалдан авалтын үйл ажиллагаа хангалтгүй байгаад дүгнэлт хийж хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцож ажил сайжруулахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгож ажилсаны үр дүнд банкны худалдан авалтад гарч байгаа зөрчил буурч байна.

Миний бие банкны ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэг хариуцлагын дагуу ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд тухай бүр биечлэн оролцож ТУЗ-өөр хэлэлцэгдэж байгаа баримт материалуудтай нэг бүрчлэн танилцаж, бүхий л асуудалд санал, дүгнэлтээ хараат бусаар гаргаж албан үүргээ бүрэн биелүүлж ажиллаж байна.

Тайлан бичсэн



С.Цэнд-Аюуш /ТУЗ-ийн хараат бус гишүүн/